



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

6 ДУГААР САРЫН ОНЦЛОХ АЖЛУУД

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР




Төрийн албаны зөвлөлөөс томилогдсон ажлын хэсэг 2023 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Соёл, урлагийн газрын “Хүний нөөцийн мэдээллийн удирдлагын тогтолцоо” цахим систем дэх мэдээллийн бүрдүүлэлт, хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаанд хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.



Соёлын сайдын Аймгийн Засаг даргатай байгуулсан 2023 оны гэрээний биелэлтийг эхний хагас жилээр **85.2 хувийн үнэлгээтэй** тайлагнав.

Биелэлтэд аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс хяналт, шинжилгээ үнэлгээ хийж Соёлын яаманд хүргүүлсэн.




Соёл, урлагийн газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг цахим санд хугацаанд нь тайлагнаж, хяналт, шинжилгээ хийж баталгаажуулсан. Мөн Соёлын байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг хяналтад авч аймгийн ЗДТГ-ын ТЗҮХ-т хүргүүллээ.



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

6 ДУГААР САРЫН ОНЦЛОХ АЖЛУУД

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР



Соёлын урлагийн газар, соёлын байгууллагуудын албан хаагчид 6 дугаар сард “Төрийн албаны шинэчлэл Төрийн албан хаагчдын зорилт, хандлага, зан үлийн өөрчлөлт” сургалт, “Төрийн албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх” сургалт, Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” болон төлөвлөгөөт сургалтуудад хамрагдav.

Соёлын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газраас өгсөн үүрэг чиглэлийн дагуу Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Соёлын тухай хууль, Номын сангийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд харьяа соёлын байгууллагын бүтэц, орон тоог баталсан, цалин хөлсийг шинэчлэн тогтоосон шийдвэрийг хянан үзэж, үнэлэлт дүгнэлт өгөхийн зэрэгцээ мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Дархан-Уул аймгийн соёлын байгууллагуудын **2023 оны II УЛИРЛЫН ҮИЛ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК** мэдээг нэгтгэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагч Соёл, урлагийн газарт хүргүүлэв.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛЫН САЛБАРЫН 6 ДУГААР САРЫН ОНЦЛОХ АЖЛУУД

БҮХ НИЙТИЙН СОЁЛЫН БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР



Соёл, урлагийн газар, Соёлын байгууллагуудаас зусландаамарч буй хүүхдүүдэд **НҮҮДЛИЙН АХУЙ, ҮНДЭСНИЙ СОЁЛЫН ӨВ, УЛАМЖЛАЛЫГ СУРТАЛЧЛАН ТАНИУЛАХ ХӨТӨЛБӨР**ийг аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгуулж эхэллээ.

Хамгийн эхний хөтөлбөрт Хөвсгөл, Сэлэнгэ, Орхон, Булган, Дархан-Уул зэрэг 5 аймгийн хүүхдүүдийн чуулга уулзалтад оролцож буй Тусгай ээлжийн 280 хүүхэд, хоёр дахь хөтөлбөрт Зулзага зуслангийн эхний ээлжийн 220 хүүхэд хамрагдав.

“МОНГОЛ БАХАРХАЛ” соёлын боловсролын хөтөлбөрөөр аймгийн Музейгээс уламжлалт тоглоом наадгай “Хорол, Үйчүүр”, “Чүүчамай”, “Дөрвөн бух”, “Тэмээн таваг” зэрэг хөлөгт тоглоомуудыг зааж сургасан бол Хүүхдийн номын ордоос “Угийн бичиг” гэж юу вэ? “Түүнийг хэрхэн хөтлөх, ураг төрлөө танин мэдэхүй” сэдвээр сургалт хийв.

Мөн монгол гэрийн бүтэц зохион байгуулалтын талаар хүүхдүүдэд танилцуулж, сургагч багш нар бий биелэгээ зааж байна.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛЫН САЛБАРЫН 6 ДУГААР САРЫН ОНЦЛОХ АЖЛУУД

СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР



Дархан-Уул аймгийн Засаг даргын дэмжлэг санхүүжилттэйгээр
**“СЯНЬБИГИЙН ХААД ЯЗГУУРТНЫ БУНХАНТ БУЛШНЫ МАЛТЛАГА
СУДАЛГАА”** –ны ажил 2023 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс үргэлжилж
байна.

Малтлага судалгаанд тулгуурлан дэлхийн жишигт нийцсэн аялал
жуулчлалын музейг дурсгалт газар дээр зохион байгуулах системтэй ажлыг
зохион байгуулж хээрийн ИЛ МУЗЕЙ байгуулах урьтач бүх нөхцөлийг
бүрдүүлэхэд энэ судалгааны ажлын үндсэн зорилго оршиж байна.



Өнгөрсөн жил тус малтлагаас 26 дэсийн 28
ширхэг олдвор олдсон билээ.



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

6 ДУГААР САРЫН ОНЦЛОХ АЖЛУУД

СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР



“СОЁЛЫН ӨВ” улсын эчнээ олимпиадын гуравдугаар байранд ЕБ-ын 16 дугаар сургуулийн 12в ангийн сурагч Б.Сайханзаяа, удирдсан багш н.Болортuya, ОИЦ сургуулийн 11-1 ангийн сурагч А.Цэнгүүн, бэлтгэсэн МУ-ын зөвлөх ТНУ-ны багш Б.Мөнхжаргал нар тус тус шалгарлаа.

Иргэд, сүм хийдэд хадгалагдаж байгаа баримтат өвийг бүртгэлд хамруулах ажлын хүрээнд Хонгор сумын Эрхэт багийн иргэн Ч.Хишигбалд өвөө Дэндэвийн Товуудоржоос /1875-1968/ өвлөгдөн ирсэн 22 судар бичгийг Хараагийн Дарь эхийн Гэцогдаржайлиин хийдийн лам нар, Соёл, урлагийн газрын соёлын өвийн мэргэжилтэн, аймгийн Музейн бүртгэл мэдээллийн санч, эрдэм шинжилгээний ажилтнуудын бүрэлдэхүүнтэйгээр бүртгэн баримтжууллаа.

Д.Товуудоржны Ардын засгаас өмнө “Богд Хааны ордон”-ны хаалгач хийж байжээ.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛЫН САЛБАРЫН 6 ДУГААР САРЫН ОНЦЛОХ АЖЛУУД

СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭР



Орхон сумын Соёлын төв, тус сумын ЗДТГ-аас хамтран Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, Сум орон нутгийнхаа Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газруудыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, хайллан хамгаалах зорилгоор "**МОРИНАЯЛАЛ**"-ыг 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс зохион байгуулж эхэллээ.

Орхон суманд Адуунчuluун уулын "Өврийн бичээс", Адуунчuluун бичигт хад, Баян-уулын хиргисүүр, Хустайн амны адаг, Адуун шивээ цамхаг зэрэгтүүх, соёлын үл хөдлөх дурсгалт 5 газар бүртгэлтэй байдаг юм.

Улсын болон аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг иргэн, хуулийн этгээдэд хариуцуулан гэрээ байгуулах, дүгнэж, урамшуулах ажлын хүрээнд. Орхон сумын Соёлын төвөөс тус сумын нутаг дэвсгэрт орших Адуун чuluуны өврийн бичээс, Адуун чuluуны бичиг хад орчимд зусаж буй

Сумын аварга малчин Сайнхүүтэй харуул хамгаалалтын талаар ярилцаж гэрээ байгуулжээ.

Соёлын өвийг хамгаалах үйлсэд нэгдсэн Танд **ТАЛАРХАЛ** илэрхийлье.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛЫН САЛБАРЫН 6 ДУГААР САРЫН ОНЦЛОХ АЖЛУУД

БҮХ НИЙТИЙН СОЁЛЫН БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭР



Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн нээлтийн тоглолтыг аймгийн ГБХЗХГ, БТСГ, БШУГ, Залуучууд театр, Хүүхэд хөгжлийн ордны дэргэдэх дугуйлангуудтай хамтран зохион байгууллаа.

Мөн Соёлын байгууллагууд соёлын үйлчилгээгээр бэлэг барьлаа.



Хүүхдийн номын ордоос Цардмал талбайн зургийн уралдааныг 4-11 насны 40 хүүхэд, Монгол ёс заншил, танин мэдэхүй" сэдэвт AXA тэмцээнд 9-11 насны 51 хүүхэд тус тус хамрагдлаа. Шинэ номын үзэсгэлэн, Уншлага үйлчилгээг зохион байгууллаа.



Аймгийн Төв номын сангаас "ХӨГЖӨӨНТ ТОГЛООМ" буюу дүрст шоо эвлүүлэх, бодьё, сэтгэе, холбоё, саная 4 төрөлт үг эвлүүлэх тоглоом зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж 60 гаруй хүүхэд оролцлоо.

Оюун ухаанаа сорьсон дүү нартаа газрын зураг, номыг дээжлэн бэлэглэв.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛЫН САЛБАРЫН 6 ДУГААР САРЫН ОНЦЛОХ АЖЛУУД

БҮХ НИЙТИЙН СОЁЛЫН БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭР



Олон Улсын Хүүхдийн Эрхийг Хамгаалах өдрийг тохиолдуулан аймгийн Музейгээс Дархан-50 цогцолборт "БИ ЗУРААЧ" ART DAY хөтөлбөр, уламжлалт хөлөгт наадгай Чүүчамай, 4 бух, тэмээн таваг зэрэг сонирхолтой тоглоомуудыг зааж, 180 гаруй хүүхэд багачуудад үйлчиллээ.



Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан **ДАРХАНЫ ҮДЭШ** шоу тоглолтод Залуучууд театрын болон Дарханы чөлөөт уран бүтээлчид оролцожаяа дуугаа өргөн барьлаа.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛЫН САЛБАРЫН 6 ДУГААР САРЫН ОНЦЛОХ АЖЛУУД

БҮХ НИЙТИЙН СОЁЛЫН БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭР



Зулзагын гол Нүүдлийн номын сан

Зусланд амрагч хүүхдүүдэд номын сангаар үйлчлэхээс гадна танин мэдэхүйн уралдаан тэмцээн зохион явуулдаг уламжлалын дагуу монгол ахуйн талаар танин мэдэхүйн мэдээлэлөгч шагайн наадгайг тоглуулах үйл ажиллагааг явуулж эхэллээ.

Аймгийн **Хүүхдийн номын ордоос** “Оюунлаг Дарханчуудыг бүтээнэ” уриан дор “УДШИЙН УНШЛАГА-2023” номын сангийн уншлага үйлчилгээг 6 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд Миний монгол цэцэрлэгт хүрээлэнд, 28-30-ны өдрүүдэд Дархан 50 цогцолборт тус зохион байгууллаа.

Номын сангийн уншлага үйлчилгээнд нийтхүүхэд хамрагдлаа.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛЫН САЛБАРЫН 6 ДУГААР САРЫН ОНЦЛОХ АЖЛУУД

БҮХ НИЙТИЙН СОЁЛЫН БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭР



Аймгийн Төв номын сан болон салбар номын сан нь 2023 оны 06 сарын 17-ны өдрөөс 07 сарын 03-ны өдрийг хүртэл номын фондын тооллогыг зохион байгууллаа.



Төв болон Уншлагын салбарын фондын тооллогыг “**НОМЫН НЭГ БҮРЧИЛСЭН БҮРТГЭЛ**” буюу дансаар, мөн бар кодоор ном тоолох хэлбэрийг сонгон тоолж байгаа бөгөөд Төв уншлагын танхимын 11 979 нэр төрлийн 13 985 боть 121.716.811.76 төгрөгийн ном тоолохоос 7 440 нэр төрлийн 8 488 боть 88.310.209.25 төгрөгийн ном Салбар номын сангийн 8 627 нэр төрлийн 10 291 боть 52.686.720.16 төгрөгийн ном тоолохоос одоогоор 4 655 нэр төрлийн 4 901 боть 32.100.935.36 төгрөгийн номыг тоолоод байна.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛЫН САЛБАРЫН 6 ДУГААР САРЫН ОНЦЛОХ АЖЛУУД

УРЛАГ, УРАН БҮТЭЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР



Ардын хувьсгалын 102 жилийн ой, Дархан хотын 62 жилийн ой, Үндэсний их баяр наадмын нээлт, хаалт, Хүндэтгэлийн концертын бэлтгэл ажил эхэллээ.

"Эв мэнхийн тусгаар Монгол" уриан дор зохиомжилж буй нээлт, хаалтын ёслолд мэргэжлийн урлагийн болон чөлөөт уран бүтээлчид, дуу, бүжиг, морин хуур зэрэг дугуйлангийн сурагчид оролцох юм.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, сум орон нутгийнхаа иргэдэд сурталчилан таниулах зорилгоор Орхон сумын Соёлын төвийн хамт олон сумынхаа соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчид, дугуйлангийн сурагчдын хамтарсан гурван үеийн "ЗАЛГАМЖ" тоглолтыг өргөн барив.

Тоглолтын найруулагчаар Соёлын төвийн дарга Б.Мөнхчулуун, бүжгийн багшаар МУСТА М.Оюунтуяа, Хөгжмийн багшаар МУСТА Б.Алтансүх нар ажилласан байна. Залгамж тоглолтыг тус сумын 300 гаруй иргэн үзэж сонирхов.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛЫН САЛБАРЫН 6 ДУГААР САРЫН ОНЦЛОХ АЖЛУУД

БУЖГИЙН КЛУБҮҮД АМЖИЛТ БҮТЭЭЛ АРВИН БАЙВ



WDC холбоо Япон улсын JBDF холбооноос зохион байгуулсан Дэлхийн Супер Цуврал 44 наадамд Дарханчууд амжилттай оролцлоо.

Өсвөр насны стандарт төрөлд Маргад-Эрдэнэ, Эрдэнэжаргал хагас финал 9-р байр, Латин төрөлд Мөн хагас финал 8-р байр, **Amateur Latin төрөлд** Vision dance club-ийн Насанбат, Золзаяа 71 хосоос латин төрөлд 1/8 финал (49) тус тус шалгарлаа.



2023 оны 06 дугаар сарын 26-нд болсон Говьсүмбэр аймагт зохион байгуулагдсан нийтийн Цэнгээнт бүжгийн нээлттэй тэмцээний "ШИЛДЭГ КЛУБ" цомын эзнээр Хос хэмнэл клубийнхэн боллоо. Тэмцээн нийт үндсэн 4 төрөл, 16 ангиллаар явагдаж нийт 67 хосын 134 бүжигчин оролцжээ.

Та бүхэндээ баяр хүргэе ээ.



Дорноговь аймагт зохион байгуулагдсан НИЙТИЙН БУЖГИЙН СПОРТЫН VII ИХ НААДАМД Дархан-Уул аймгаас Ахмадын "Шинэ үе", "Жигүүр", Залуусын "Хөсөгтөн" зэрэг нийтийн бүжгийн хамтлагууд оролцож 18-45 насны ангилалд Хөсөгтөн хамтлаг "ТЭРГҮҮН БАЙР" эзэлж цом, ёргөмжлөл, алт, мөнгөн медалиар тус тус шагнагдлаа.

Та бүхэндээ баяр хүргэе!

СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

ТОГТВОРТОЙ НОГООН САНХҮҮЖИЛТ ДАРХАН - ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ФОРУМД ОРОЛЦЛОО



2023 оны 6 дугаар сарын 29-өөс 7 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсан **“ТОГТВОРТОЙ НОГООН САНХҮҮЖИЛТ-ДАРХАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ФОРУМ”**-д Соёлын яам, Монголын Үндэсний Кино урлагийн зөвлөл Соёл, урлагийн газрын төлөөлөл оролцов.

Тус форумын 2 дахь өдөр Соёлын яамны Соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацийн хэлтсийн дарга Г.Батхуяг Бүтээлч хот – Тогтвортой хөгжил “**Соёлын илэрхийлийн олон талт байдал хотын хөгжлийн стратегийн гол хүчин зүйл болохнь**” сэдвээр, Монголын үндэсний Кино урлагийн зөвлөлийн дарга Ч.Ундрал “**Кино аялал жуулчлал болон соёлын сонирхол**” –ын талаар сонирхолтой мэдээлэл өглөө.

Форумд бодлогын яамдын шинжээчид, орон нутгийн бодлого тодорхойлогчид, Словани, Бельги, Хойд Макадони, Румин, Грек, Чех, Япон, Солонгос зэрэг орнуудын эксперт хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчид, судлаач эрдэмтэд, энтрепенер зэрэг 200 гаруй төлөөлөгчид урилгаар оролцлоо.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛЫН САЛБАРЫН 6 ДУГААР САРЫН ОНЦЛОХ АЖЛУУД

КОМАНД ШТАБ БОЛОН ГАМШГААС ХАМГААЛАХ ИЖ БҮРЭН СУРГУУЛЬД ХАМРАГДЛАА



Дархан-Уул аймагт 2023 оны 06 дугаар сард зохион байгуулагдсан **Команд штабын** сургууль болон **Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд** аймгийн Соёл, урлагийн газар, Соёлын байгууллагууд тус тусын чиг Үүргийнхээ дагуу оролцлоо.

Тухайлбал:

- Соёл, урлагийн газар аймгийн Онцгой комисст болон дадлага сургуулийн үеэр Ар тал, хангалтын багийн гишүүнээр томилогдон ажиллав.
- Соёлын төвүүд Сумдын Онцгой комисст болон Нүүлгэн шилжүүлэлтийн ажилд дайчлагдлаа.
- Залуучууд театрын уран бүтээлчид мэргэжлийн ангийн тактикийн үзүүлэх сургуульд дуурайлган үзүүлэх, газар хөдлөлтийн аюулын үед хүн амыг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлэх дадлага сургуульд урлаг, соёлын үйлчилгээгээр тус тус хамтран ажиллалаа.